

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	2
2.1. Оршил .....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	9
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
М.БАТГЭРЭЛ ТАНАА

2020.02.21 № 06/578  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрчим хүчний яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Дуусаагүй барилга, байгууламжийн дансанд 7 жил болсон өнөөг хүртэл ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, асуудал нь шийдвэрлэгдээгүй 2,323,808.2 мянган төгрөгийн 2 барилга байгууламж байгаа нь үнэн зөв, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.1. Оршил

Эрчим хүчний яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Батгэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийх, өглөг, авлагыг тооцоо нийлсэн акт, гэрээний дагуу санхүүгийн тайланд үнэн, зөв тусгах, орлого, зарлагыг бүрэн тусгах, дотоод хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрчим хүчний яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Түвшинзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн В/253 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангахад оршино.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;
- Эрчим хүчний нүүрсний болон шинэ хийн түлшний технологийг хөгжүүлэх, инновацийг дэмжих;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрчим хүчний яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2014 онд боловсруулсан, түүнээс хойш Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой холбоотой өөрчлөлтийг бодлогын баримт бичигтээ шинэчлэн боловсруулаагүй байна.

Эрчим хүчний яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Эрчим хүчний яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Эрчим хүчний яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6, гүйцэтгэлийн үе шатанд 6 асуудалд 12 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 31,874,436.6 мянган төгрөгөөс тооцон 637,488.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолоогүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрчим хүчний яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,533,658.6 мянган төгрөгөөр буюу 55.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	198.6		(198.6)
Авлага	1,479.1	349.1	(1,130.1)
Урьдчилгаа			-
Бараа материал	25,262.4	22,346.4	(2,916.0)
Үндсэн хөрөнгө	9,982,943.9	4,453,529.9	(5,529,414.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,009,884.0</b>	<b>4,476,225.4</b>	<b>(5,533,658.6)</b>
Өр төлбөр	10,409.4	285.3	(10,124.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,999,474.6	4,475,940.1	(5,523,534.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>10,009,884.0</b>	<b>4,476,225.4</b>	<b>(5,533,658.6)</b>

Авлага дансны эхний үлдэгдэл ажиллагсадтай холбогдсон үүссэн 1,479.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба тайлант онд байгууллагаас авах 141.8 мянга, хувь хүнээс авах 207.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,916.0 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын данснаас бараа материал тавьж олгосонтой холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 22,346.4 мянган төгрөгийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь 2009-2014 онд улсын комиссын актаар ашиглагч 6 байгууллагад шилжүүлсэн 5,366,729.0 мянган төгрөгийн дуусаагүй барилга, байгууламж болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 216 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 66,974.7 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Лексус 570 автомашиныг балансаас балансад шилжүүлсэн боловч тухайн онд данс бүртгэлээс хасаагүй байсныг 2019 онд данс бүртгэлээс хассантай холбоотой байна. Мөн тус газрын 2019 оны 235 дугаар тогтоолоор 37,173.5 мянган төгрөгийн өртөгтэй Ниссан теана автомашиныг Цаг уур, орчны шинжилгээний газарт шилжүүлсэн, 2019 оны 235 дугаар тогтоол, 2019 оны А-1/4020 тоот албан бичгээр 54,081.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ

төлбөргүй шилжүүлсэн, 2019 оны 291 дугаар тогтоол, тус оны А-2/2527 тоот албан бичгээр акталсан 46,389.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна. Тайлант онд “Эрчим хүчний үр ашиг 3+” төслийн нэгж татан буугдсантай холбоотойгоор 160,629.8 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө шилжиж нэмэгдсэн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны эхний үлдэгдэл “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас 2008 онд авсан ялтсан бойлуурын зээлийн үлдэгдэл 10,210.9 мянган төгрөгийг тайлант онд барагдуулж дуусгасан байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд 2019 онд үүссэн 285.3 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой буюу нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 18,887,340.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Нийт төсвөөс 1,737,340.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 17,150,000.0 мянган төгрөгийг эрчим хүчний үйлдвэрүүдийн цахилгаан, дулааны алдагдлын татаасын санхүүжилтийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 18,856,600.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа ба зарцуулаагүй үлдэгдэл 30,938.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан үзэхэд дараах зардлууд хэмнэгдсэн байна. Үүнд: Цалин хөлснөөс 354.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 15,394.6 мянган төгрөгийг хэмнэсэн нь тайлант онд 15 ажилтан орон тооноос дутуу ажилласан, байр ашиглалттай холбоотой зардлаас 4,965.0 мянган төгрөг хэмнэсэн нь цахилгааны төлбөрийн циклийн хугацаанаас хамаарсан, хангамж бараа материалаас 39.2 мянган төгрөг, нормативт зардлаас 64.9 мянган төгрөг хэмнэсэн нь материал худалдан авалтаас, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 1,137.6 мянган төгрөг хэмнэсэн нь мэдээлэл технологи болон маягт хэвлүүлэх зардал багассан, Засгийн газрын хоорондын шилжүүлгээс 1,585.4 мянган төгрөг хэмнэсэн нь гишүүнчлэлийн татвар төлөөгүй, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 7,301.5 мянган хэмнэсэн нь тэтгэвэрт гарахаар төлөвлөсөн ажилтан хугацаа болоогүй шалтгаанаас тэтгэвэрт гараагүйгээс шалтгаалсан байна.

Эрчим хүчний үйлдвэрүүдийн дулаан, цахилгааны алдагдлын татаасын санхүүжилтэд 17,150,000.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 8 дулааны цахилгаан станцад бүрэн олгосон байна.

**Нэмэлт төсөв:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам 12,750,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого орсноос “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д 12,722,000.0 мянга, “Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр анги” ХНН-д 28,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,410,059.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 53,263.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,356,795.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнд:



Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн, оршин байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй дараах алдаануудыг санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 216 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 215,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Лексус 570 автомашиныг балансаас балансад шилжүүлсэн боловч 2017 онд данс бүртгэлээс хасаагүй, 35,833.3 мянган төгрөгийн элэгдэл тооцож тайлант оны үр дүнг буруу илэрхийлсэн;
- Санхүүгийн тайлангийн барилга байгууламжийн эхний үлдэгдлийг 2018 оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 5,577.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Худалдаж авсан 8,540.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалд тусгалгүй зардалд шууд тусгасан;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр балансаас балансад шилжиж үнэ төлбөргүй хүлээн авсан 3,333.2 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Аудитаар илэрсэн 2,356,795.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дуусаагүй барилга, байгууламж дансны үлдэгдлийг дараагийн аудитаар анхааран авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тухайн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зардал, концессын зүйл жагсаалтын мэдээллийг хугацаанд нь 129, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан 18 мэдээлэл байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,843.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, нийт 3 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрчим хүчний яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 2,356,795.3 мянган төгрөгний алдаа, зөрчил нь бидний тогтоосон 637,488.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлтийг өгч байна.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрчим хүчний яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Дуусаагүй барилга, байгууламж данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Дуусаагүй барилга, байгууламж дансанд 2012 онд бүртгэсэн 2,323,808.2 мянган төгрөгийн дуусаагүй 2 барилга байгууламжаас 842,208.2 мянган төгрөгийн байгууламжийг 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 41/2019 дугаар улсын комиссын актаар ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн ч тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасаагүй, 1,481,600.0 мянган төгрөгийн дуусаагүй барилга байгууламж нь 7 жилийн хугацаанд өдийг хүртэл ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хөрөнгө санхүүгийн тайланд давхар илэрхийлэгдэх, элэгдэлийн зардал буруу тайлагнах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Дуусаагүй барилга, байгууламжид бүртгэлтэй барилгуудын асуудлыг шийдвэрлэх

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

#### **3.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ болон зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд 18,056.5 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн

захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудыг зөрчиж, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2.2 Эрсдэл:**

Төсвийг үрэлгэн зарцуулах, төлөвлөлтийг үндэслэлгүй хийх

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Цаашид батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

**3.3 *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

**3.3.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд 4,033.2 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байгаа нь УСНББОУС 17-д “Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а/ Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслүүлэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшин байгаа ба б/ нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэсэн заалттай нийцэхгүй, толилуулаг тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.3.2 Эрсдэл:**

Тайлант оны элэгдэл буруу илэрхийлэгдэх

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Дээрх бараа материалын шинж чанартай хөрөнгийг ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийж, бараа материалын дансанд тусгах

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно

**3.4 *Урт хугацаат өр, төлбөрийн данстай холбоотой асуудал***

**3.4.1 Илрүүлэлт:**

Өмнөх оны урт хугацаат 10,210.8 мянган төгрөгийн өрийн үлдэгдэл нь дамжуулан зээлдэгчээс зээл ашиглалттай байгуулсан гэрээнд тусгагдсан зээлийн үлдэгдэл 13,812.5 мянган төгрөгөөс зөрүүтэй, тайлант онд зээл барагдуулсан төлбөр дансны үлдэгдлээс их байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...14.4.3 бүх өр төлбөр”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**3.4.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Өглөг, авлагыг тооцоо нийлсэн акт, гэрээний дагуу санхүүгийн тайланд үнэн, зөв тусгах

**3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

**3.5 *Орлого данстай холбоотой асуудал***

**3.5.1. Илрүүлэлт:**

Тендерийн орлогыг бууруулах бичилт хийхдээ 270.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд цэвэрлэж тайлагнасан, цалингийн суутгалаас үүссэн

645.4 мянган төгрөгийн бусад орлогыг үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...14.4.5-т бүх орлого” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.5.2. Эрсдэл:**

Орлого дутуу тусгах

**3.5.3. Өгсөн зөвлөмж:**

Бүх орлого, зарлагыг мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд тусгах

**3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

**3.6 Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

**3.6.1. Илрүүлэлт:**

Ажиллагсдаас авах 493.6 мянган төгрөгийн авлагыг цалингаас суутган тооцоходоо тухайн ажилтнаас бус өөр ажилтнаас суутгасан, 2 ажилтнаас 400.0 мянган төгрөгийг үндэслэлгүй суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.6.2. Эрсдэл:**

Авлагыг үндэслэлгүй бууруулсан байх

**3.6.3. Өгсөн зөвлөмж:**

Ажиллагсадтай тооцоо хийхдээ тухайн ажилтантай тооцоо хийх мөн тушаал шийдвэрийн дагуу ажиллагсдын цалингаас цалингийн суутгал хийх

**3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

**3.7 Татварын тайлантай холбоотой асуудал**

**3.7.1. Илрүүлэлт:**

Ажиллагсдын цалингаас суутгасан татварыг татварын байгууллагад 5,477.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т “суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.7.2. Эрсдэл:**

Татварын тайланг буруу тайлагнах

**3.7.3. Өгсөн зөвлөмж:**

Дотоод хяналтыг сайжруулах

**3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

